| 3.17 | Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлэх, бүртгэх | Улсын төсөв | Чадавхаа үнэлүүлж, мэдээллийн санд бүртгэгдсэн аж ахуйн нэгж, тоо | 192 | 220 | Нийт 41 ААНБ чадавхаа үнэлүүлэхээр хүсэлт гаргаснаас 27 ААНБ нь үнэлгээнд тэнцэн, Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд шинээр бүртгэгдсэн.<br>- Анхдагч үнэлгээ хийлгэх хүсэлт ирүүлсэн 27 ААНБ-ын асуудлыг дүгнэсэн ажлын хэсгийн дүгнэлтийг ХЗЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.<br>- Давтан үнэлгээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн 14 ААНБ-ын асуудлыг ажлын хэсгийн дүгнэлтээр шийдвэрлүүлсэн.<br>- Магадлан үнэлгээнд 10 ААНБ хамрагдсан. | 100 |
| 3.18 | Хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулах | Улсын төсөв | Баталгаажуулсан хэмжих хэрэгслийн тоо | 243,709 | 202,000 | Нийт 251,923 хэмжих хэрэгсэл баталгаажуулсан. Баталгаажуулсан хэмжих хэрэгслийг лаборатори тус бүрээр харуулбал:<br>✓ ХХХБЛаборатори 14,440 ш<br>✓ ЦХХБЛаборатори 175,785 ш<br>✓ ЭЗХХБЛаборатори 54,974 ш<br>✓ ДДЭМХХБЛаборатори 6724 ш | 100 |
| 3.19 | Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн чиглэлээр төлөвлөгөөт болон захиалгат, нэмэлт сургалтыг зохион байгуулах | Улсын төсөв | Зохион байгуулах сургалтын тоо | 45 | 45 | Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн чиглэлээр төлөвлөгөөт, захиалгат, нэмэлт сургалтуудыг нийт 60 удаа зохион байгуулсан. Үүнд:<br>✓ Төлөвлөгөөт сургалт–30 удаа<br>✓ Захиалгат сургалт – 10 удаа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Нэмэлт сургалт – 20 удаа | |
| 3.20 | Стандарт, хэмжил зүйн газрын бүтцийн нэгжүүд болон аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх , арга зүйн зөвлөмж өгөх | Улсын төсөв | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тоо | Нэгж- 8 Аймаг-7 | Нэгж-8 Аймаг- 10 | 1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол болон СХЗГ-ын даргын 2022 оны А/99 дугаар тушаалаар батлагдсан "Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын дагуу зохион байгуулалтын 8 нэгж болон 20 аймаг дахь Стандарт хэмжил зүйн хэлтсийн эхний хагас жил болон жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан.<br>2. Мөн газрын даргын баталсан удирдамжийн дагуу аймаг дахь 12 Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт-шалгалтыг зохион байгуулж холбогдох чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан.<br>3. 2022 оны 158 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулалтын бүтцийн 8 нэгжид 09-11-р сард хяналт шинжилгээ хийж, нийт 98 ажил сайжруулах зөвлөмж өгсөн. Дүгнэлт, зөвлөмжийг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, нэгжийн дарга нарт хүлээлгэн өгсөн. | 100 |
| 3.21 | Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх | Улсын төсөв | Хүчин төгөлдөр санамж бичиг, хамтран ажиллах төлөвлөгөөтэй олон улсын байгууллагын тоо | 25 | 28 | СХЗГ-аас хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд хүчинтэй санамж бичиг-13, гэрээ, хэлэлцээр-10, хугацаа дууссан 2 санамж бичиг байна.<br>1 санамж бичиг, 2 гэрээг шинээр байгуулахаар ШСАА-нд санал авахаар хүргүүлсэн. (Байгууллага хоорондын гэрээ байгуулах тухай Засгийн газрын 57-р тогтоолын 4.1-т заасны дагуу). Дараах 4 (дөрөв) байгууллагатай шинээр гэрээ, санамж бичиг байгуулахаар ажиллаж байна. Үүнд:<br>1. СХЗГ болон Казахстаны Стандартчилал, хэмжил зүйн хүрээлэн (Kazstandard) хоорондын Стандарт түгээлтийн гэрээ<br>(Шадар сайдаас саналыг авсан. Саналын дагуу Казахстаны Стандартчилал, хэмжил зүйн хүрээлэн рүү илгээсэн. Зөвшөөрсөн тохиолдолд гадаад харилцааны яам руу гэрээг байгуулах зөвшөөрөл авахаар албан бичиг явуулна.)<br>2. СХЗГ болон АНУ-ын 'Underwriters laboratories Inc.' (Андеррайтерс лабораториз ХК) хоорондын хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичиг (Канад | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-нд болон Андеррайтерс лабораториз ХК-д төслийг албан бичгээр хүргүүлсэн)<br>3. СХЗГ болон Бүгд Найрамдах Турк Улсын Шинжлэх Ухаан, Технологийн Судалгааны Зөвлөл ('TUBITAK') хоорондын хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичиг (Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахад бэлэн болсон)<br>4. СХЗГ болон Бүгд Найрамдах Турк Улсын Халал итгэмжлэлийн агентлаг хоорондын хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичиг (Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахад бэлэн болсон). | |
| **4** | **Зорилт 4. БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, НӨӨЦИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ** | **Улсын төсөв** | **Арга хэмжээний хэрэгжилт, %** | **100** | | **Орлогын биелэлт 140,0 хувь, жил эцсийн байдлаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг 10 удаа холбогдох журмын дагуу зохион байгуулсан .**<br>**Төвийн хэмжээнд Төрийн захиргааны албан тушаалын орон тоо 71, Төрийн үйлчилгээний албан хаагч 48 байна. Төрийн захиргааны албан хаачдаас тайлант хугацаанд 9 албан хаагчийг төрийн захиргааны албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад хамруулаад байна.** | **100** |
| 4.1 | Үндсэн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлэх, хянах | Улсын төсөв | Батлагдсан төсвийн хуваарийн дагуу | 3.5 тэрбум | 4.9 тэрбум | Үндсэн үйл ажиллагааны орлого 140,0 %-иар биелсэн. Үүнд:<br>✓ Хэмжил зүйн хүрээлэн – 84,622,450 төгрөг<br>✓ Шалгалт тохируулгын орлого 90,106,600 төгрөг<br>✓ Хэмжих хэрэгсэл шалгалт баталгаажуулалтын газар- 2,077,823,700 төгрөг<br>✓ Бүтээгдэхүүн тогтолцоо баталгаажуулалтын орлого 323,274,500 төгрөг;<br>✓ Стандарт борлуулалт, сургалтын орлого 234,000,000 сая төгрөг;<br>✓ Сорьцын лабораторийн орлого 2,092,800,000 төгрөг; | 100 |
| 4.2 | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайланг хуулийн хугацаанд үнэн зөв илэрхийлэх; | Батлагдсан төсөв 4,551.9 сая төгрөг | Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргах, Өр, авлага, | 2021 онд Газрын төсвийн гүйцэтгэл 4,542.5 | Батлагдсан төсвийг хэмнэлттэй зарцуулна. | Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомжийг үндэслэн батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал тус бүрээр зориулалтын дагуу зарцуулан 3,714,900,000 төгрөгийн төсвийн гүйцэтгэлтэй ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гүйцэтгэлийн мэдээг сар бүр авч нэгтгэх, орлого нийлэх | сая төгрөг. | | | |
| 4.3 | Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах. | Улсын төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 4 | 8 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж “Худалдан авах ажиллагааны цахим систем”-д худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулсан. Үүнд:<br>- Шинжилгээний зориулалттай Купеляцийн зуух<br>- Сорьц дарах лазер төхөөрөмж<br>- “Эм, эмнэлгийн хэрэгсэл, химийн урвалж<br>- Цахим хурлын заалны тоног төхөөрөмж<br>- Төв, орон нутгийн хэлтсүүдэд “хэмжил зүйн эталон, лабораторийн тоног төхөөрөмж<br>- Компьютер болон бусад шаардлагатай тоног төхөөрөмж<br>- Орон нутгийн хэлтсүүдэд хөдөө ажлын туулах чадвартай технологийн автомашин<br>- Хэмжил зүйн лабораториудын өрөөний засвар хийх.<br>- Хэмжил зүйн эталон, лабораторийн тоног төхөөрөмж<br>- “Стандарт, хэмжил зүйн салбарын технологийн зориулалттай автомашин | 100 |
| 4.4 | Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах, дүн шинжилгээ хийх, Үндэсний аудитын газраар хянуулж, баталгаажуулах | Улсын төсөв | Тайлангийн тоо | 4 | 4 | 2021 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг 2022 оны оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн.<br>2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газраас 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс явцын аудит хийгдэж байна. | 100 |
| 4.5 | Төв, орон нутгийн СХЗХ-үүдийн 2023 оны урсгал төсөв, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг нэгтгэх, батлуулах | Улсын төсөв | Батлагдсан төсөв | 9.1 тэрбум | 9.2 тэрбум | Нийт 5 хөтөлбөрөөр 118 арга хэмжээний 13,523.6 сая төгрөгийн саналыг ШСАА-нд хүргүүлж, цахим мэдээллийн санд оруулсан болович Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ батлагдаагүй. | 100 |

| Гуравдугаар хэсэг. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **5** | **Зорилт 5. СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЛЭГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ИЛ ТОД, ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛГОХ** | **Улсын төсөв** | **Хэрэглэгчийн сэтгэл ханамж, %** | **87.9** | | **Төрийн үйлчилгээг илт тод, нээлттэй хүртээмжтэй хүргэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх санал гомдол хүлээн авах чиглэлээр 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс:**<br>- **Бүрэн хэрэгжсэн арга хэмжээ-...**<br>- **Хэрэгжиж байгаа арга хэмжээ-...**<br>СХЗГ-ын 1800-2525 тусгай дугаарт 2022.01.03-2022.12.09-ны байдлаар 10 гомдол, тусгай дугаарт 1781 дуудлага хүлээн авч шийдвэрлэсэн.<br>“Чанар” аплейкешний санал хүсэлт цэсэн дээр 12 хүсэлт ирснийг холбогдох газар нэгжүүдээр шийдвэрлүүлж, бүртгэсэн. | 92.7 |
| 5.1 | Аймгийн СХЗХ-үүдэд шалгалт тохируулгын лабораторийг бий болгох техникийн чадавхыг нэмэгдүүлэх | Улсын төсөв | Шалгалт тохируулга хийж буй хэлтэс | 2 | 13 | 1. Байгууллагын нэмэлт орлого, хөрөнгө оруулалтаар 2022 онд нийт 128 ш ажлын эталонууд шинээр нийлүүлсэн. Үүнд:<br>- Аналитик электрон жин 14 ш<br>- Цахилгааны ажлын эталон 3 ш.<br>- F1, F2 ангийн багц туухай 18 ш<br>2. 15 аймгийн СХЗХ-үүдийн нийт 16 улсын шалгагч, мэргэжилтнүүд шалгалт тохируулгын ажилтны эрх авах сургалтад хамрагдаж, чадавхаа үнэлүүлсэн. | 100 |
| 5.2 | Хэмжил зүйн Зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах | Улсын төсөв | Зохион байгуулсан Зөвлөлийн хуралдааны тоо | 8 | 8 | Хэмжил зүйн зөвлөлийн хуралдааныг 2 удаа танхимаар 4 удаа цахимаар нийт 6 удаа зохион байгуулсан. Хэмжил зүйн зөвлөлийн хуралдааны дэгийг баталж, Хэмжил зүйн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээний төсөл, ХЗХ-ийн ШУТС-ийн төслийн тайлан мэдээлэл, 19 ААНБ-ын 21 хэмжих хэрэгслийн загварын туршилт хийсэн болон Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх 27 ААНБ-ын чадавхыг үнэлсэн ажлын хэсгийн дүгнэлтийг ХЗЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. | 100 |
| 5.3 | Олон Улсын Цахилгаан техникийн Хороо (IEC)-н дахь Стандарт, хэмжил зүйн газрын гишүүнчлэлийн статусыг ахиулах урьдчилсан судалгаа гаргах | Улсын төсөв | Судалгааны тоо | - | 1 | Олон улсын цахилгаан техникийн хороо (IEC) дахь СХЗГ-ын гишүүнчлэлийн статусыг ахиулах Урьдчилсан судалгааг боловсруулсан. 2022 оны 10 дугаар сард АНУ-ын Сан-Франциско хотод зохион байгуулагдсан Олон улсын цахилгаан техникийн хорооны 86 дугаар хуралд газрын дарга оролцож статусаа ахиулах боломж нөхцлийн талаарх мэдээ, мэдээлэл авсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.4 | Хоёр талт хамтын ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх хамтарсан төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх | Улсын төсөв | Төсөл, хөтөлбөрийн тоо | - | 1 | Гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд дараах төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, МУ-ын Шадар сайдын Ажлын албанд 2022 оны 01/83 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Үүнд:<br>1. "Эрчим хүчний салбарт чанарын дэд бүтцийг хөгжүүлэх нь – №: 2014.2132.0 /4В-95310- II шат".<br>2. "Монгол Улсын Уул уурхайн салбарт чанарын дэд бүтцийг бэхжүүлэх нь" – №4В-95326 (2016.2005.3) - III шатны төсөл.<br>3. "Эрчим хүчний салбар дахь хэмжлийн түлхүүр эталон ба технологийн Хятад-Монголын хамтарсан судалгааны төсөл.<br>"Эрчим хүчний салбарт чанарын дэд бүтцийг хөгжүүлэх нь" төслийн хүрээнд ХБНГУ-ын Физик, техникийн хүрээлэн (PTB)-ийн төслийн зохицуулагчид Стандарт, хэмжил зүйн газарт 2022.09.10-2022.09.23-ны өдрүүдэд ирж ажилласан. | 100 |
| 5.5 | Орон нутгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийг Тусгай зориулалтын технологийн автомашинтай болгох | Улсын төсөв | Автомашины тоо | - | 10 | Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсүүдэд туулах чадвар сайтай тусгай зориулалтын 10 автомашин нийлүүлэхээр төлөвлөсөн холбогдох тендер шалгаруулалтыг зохион байгуулж Архангай, Сүхбаатар аймгийн СХЗХ-д автомашиныг хүлээлгэн өгөх бөгөөд Баянхонгор аймгийн СХЗХ-д автомашин авах боломж нөхцлийг хангаж өгсөн. СХЗГ-т 1 автомашиныг ашиглаж байгаа бөгөөд 4 машин хүлээлгэн өгөхөөр хүлээгдэж байгаа. 6 автомашин ирнэ.<br>Хүлээлгэн өгөхөд бэлэн болсон Шадар сайдыг хүлээж байгаа. | 100 |
| 5.6 | Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, "Стандарт, хэмжил зүй" сэтгүүлийг тогтмол эрхлэн явуулах | Улсын төсөв | Мэдээ, мэдээллийн тоо, сэтгүүлийн тоо | 50/2 | 130/4 | "Стандарт, хэмжил зүй" сэтгүүлийн I, II улирлын дугаарыг эрхлэн гаргасан. Үүнд:<br>✓ 2021 оны онцлох үйл ажиллагаа, 2022 онд хэрэгжүүлэх томоохон ажлууд.<br>✓ Дэлхийн хэмжил зүйн өдрийг тохиолдуулан "Дижитал эрин дэх Хэмжил зүй" сэдэвт.<br>Сэтгүүлийг masm.gov.mn цахим сайтад цахимаар нийтэлж, МУ-ын Шадар сайд, холбогдох бусад байгууллагад тус тус хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Нэг, хоёрдугаар улирлын сэтгүүл хэвлэмлээр, 10 дугаар сард Дэлхийн стандартын өдөрт зориулан цахим хэлбэрээр гарсан.<br>Нийт 139 мэдээ, мэдээлэл бэлтгэсэн. | |
| 5.7 | IAF certsearch олон улсын цахим хуудсанд менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж, Стандарт, хэмжил зүйн газраас гэрчилгээжсэн байгууллага, аж ахуйн нэгжийг бүртгэх, идэвхжүүлэлт хийх | Улсын төсөв | Гэрчилгээжсэн байгууллагын хувь | 60% | 75% | IAFcertsearch ОУ-ын цахим хуудсанд СХЗГ-аас менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн нийт 240 гэрчилгээжсэн байгууллагаас тухайн байгууллага Confirm хийж зөвшөөрөх ёстойгоос 180 байгууллага зөөвшөөрч гэрчилгээжиж бүртгэгдсэн. | 90 |
| 5.8 | Нийгэмд стандартчиллын талаарх ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр олон нийтэд чиглэсэн стандартын мэдээ мэдээллийн контент бэлтгэх, түгээх | Улсын төсөв | Контентийн тоо | - | 4 | Стандартын чиглэлээр 20 контент, хэмжил зүйн чиглэлээр 10 контентыг бэлтгэж байгууллагын masm.gov.mn сайт, Стандарт, хэмжил зүйн газрын мэдээлэл пэйж хуудас зэрэг олон нийтийн мэдээллийн сүлжээгээр дамжуулан түгээсэн.<br>Эмхэтгэл – 4 /4000ш/,<br>Брошур – 2 /1000ш/<br>Нээлттэй хаалганы өдөр – 2 удаа<br>1. МҮОНТ-тэй хамтын ажиллагааны хүрээнд “Олон нийтийн цаг” нэвтрүүлгээр стандартыг сурталчлах хүрээнд 3 нэвтрүүлэг гарсан.<br>2. МҮОНТ-ийн “Монголын мэдээ” мэдээллийн хөтөлбөрөөр стандартын талаар гурван удаагийн мэдээлэл гарсан.<br>3. ЖДҮГ-тай хамтран бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээний ач холбогдлын талаар видео шторк зураг авалтын шатандаа явж байгаа.<br>4. Стандарттай холбоотой асуудлаар олон нийтийн тв, сонин, сайтад 24 удаа ярилцлага, тодруулга СХЗГ-ын мэргэжилтнүүд өгсөн.<br>5. 10.14-ны Дэлхийн стандартын өдрөөр “Стандарт ба түүний хэрэгжилтийг хангах нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>6. Төв болон орон нутгийн СХЗХ-үүдээр нийт “Стандарт бидний амьдралд” сэдэвт 20 өөр стандартаар видео танилцуулга хийлгэж, байгууллагын цахим хуудсаар сурталчилсан.<br>7. Батлагдсан стандарт болон стандарттай холбоотой мэдээ мэдээлэл, сургалтын талаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 23 мэдээг байгууллагын цахим хуудсаар сурталчилсан.<br>8. “Тогтвортой хөгжлийн зорилго”, “Дэлхийн жижиг дунд үйлдвэрийн өдөр-2022” нээлттэй хаалганы өдөр болон Налайх дүүргийн Тамгын газартай хамтран зохион байгуулсан нээлттэй хаалганы өдрөөр стандартыг олон нийтэд сурталчилсан. | |
| 5.9 | Хэмжил зүйн мэдээллийн сан, Баталгаажуулалтын мэдээллийн санг хөгжүүлэх “e-Mongolia” цахим санд холбох | Улсын төсөв | “e-Mongolia” цахим санд холбогдсон мэдээлэл, Мэдээллийн сангийн хувь, | 1/50 | 48/100 | 1. **Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан:** Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санг дараах хэмжил зүйн үйл ажиллагааны чиглэлээр хөтлөх ажлыг зохион байгуулсан. Үүнд:<br>- 20 аймаг орон нутгийн СХЗХ-үүдийн шалгалт баталгаажуулалт хийгдсэн нийт 92097 хэмжих хэрэгсэл;<br>Цахилгааны хэмжлээр-59173, Температурын хэмжлээр-196, Массын хэмжлээр-11431, Даралтын хэмжлээр-3937, Эзэлхүүний хэмжлээр-10990 хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын мэдээг тус, тус мэдээллийн санд бүртгэн авсан.<br>- загварын туршилтад тэнцсэн 21 хэмжих хэрэгслийн загвар (нийт-568 загвар);<br>- хэмжих хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, засварлах, суурилуулах үйл ажиллагаа эрхлэх 27 аж ахуйн нэгж байгууллага (нийт-200 ААНБ).<br>- шалгалт тохируулга хийгдсэн нийт 17060 ажлын эталоны ба хэмжих хэрэгсэл /2022 оны 12 дугаар сарыг урьдчилсан байдлаар тооцсон болно/;<br>**Баталгаажуулалтын мэдээллийн нэгдсэн сан:** Баталгаажуулалтын мэдээллийн нэгдсэн санг “Сод электроникс” ХХК-тай гэрээ байгуулан шаардлагатай хөгжүүлэлтийг хийсэн. Тус санд одоогоор нийт 6021 мэдээлэл орсон.<br>**e-mongolia нэгдсэн систем:** Тус нэгдсэн системд e-standart.gov.mn сайт холбогдсон.<br>Хэмжил зүйн мэдээллийн сан, Баталгаажуулалтын мэдээллийн нэгдсэн санг И-Монголиа системд холбох бэлтгэл ажлыг хангасан. Үүнд:<br>✓ Мэдээллийн санг үүсгэх<br>✓ Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд тест хийх<br>✓ Программын ажиллагааг тестлэх | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.10 | Чанар гар утасны аппликейшн хөгжүүлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх | Улсын төсөв | Мэдээллийн төрөл | 3 | 5 | "Чанар" гар утасны апплейкшнийг хөгжүүлэлтийг хийн Google Play store, App store-д байршуулсан ба дараах 5 төрлийн мэдээллийг авах боломжтой болсон. Үүнд:<br>1. Мэдээ цэсээр дамжуулан Газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл.<br>2. Стандарт цэсээр дамжуулан Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 6536 стандартыг цахимаар үзэх, худалдан авах боломжтой.<br>3. Баталгаажуулалт цэсээр дамжуулан- Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын зүйл ажиллагаатай холбоотой мэдээлэл (Бүтээгдэхүүн, үйлчилгээ, менежментийн тогтолцоо, аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүн, импортын баталгаажуулалт)<br>4. Санал, хүсэлт цэсээр дамжуулан Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт өгч шийдвэрлүүлэх<br>5. 1800-2525 цэсээр дамжуулан Стандарт, хэмжил зүйн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийг автомат хариулагч болон оператортай холбогдож авах боломжтой болсон. | 100 |
| 5.11 | Стандарт, хэмжил зүйн салбар байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай шийдвэр гаргуулах | Улсын төсөв | Батлагдсан ЗГ-ын шийдвэрийн тоо | - | 1 | Монгол Улсад Стандарт, хэмжил зүйн салбар үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг СХЗГ-ын даргын 2022 оны А/81 дүгээр тушаалаар байгуулсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор баталсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-ын 1.2-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайдад салбарын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар шийдвэр гаргаж өгөх хүсэлтийг СХЗГ-ын 2022 оны 01/953 дугаартай бичгээр хүргүүлсэн. | 70 |
| 5.12 | Нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг салбарын хэмжээнд зохион байгуулах | Улсын төлөв | Зохион байгуулагдсан үйл ажиллагааны тоо | - | 1 | Налайх дүүрэгт "НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ"-ийг зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд дараах мэдээлэл, үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:<br>1. Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартын талаарх мэдээлэл, лавлагаа.<br>2. Бүтээгдэхүүн, баталгаажуулалтын ач холбогдлын талаарх мэдээлэл. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Эрдэнийн чулуун эдлэлийг гэрчилгээжүүлэх.<br>4. Бүх төрлийн хэмжих хэрэгслийг баталгаажуулах<br>5. Бусад баталгаажуулалтын ач холбогдлын талаарх мэдээлэл.<br>6. Эрдэнийн чулуун эдлэлийг гэрчилгээжүүлэх.<br>7. Бүх төрлийн хэмжих хэрэгслийг баталгаажуулах<br>8. Бусад. | |
| 5.13 | Дэлхийн хэмжил зүйн өдөр, Дэлхийн Стандартын өдрийг тохиолдуулан үйл ажиллагаа, хэлэлцүүлэг зохион байгуулах | Улсын төсөв | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 2 | 2 | Дэлхийн Хэмжил зүйн өдрийг “Дижитал эрин дэх Хэмжил зүй” уриан дор тэмдэглэх ажлын хүрээнд 20 арга хэмжээг батлагдсан хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулсан.<br>1. “Дижитал эрин дэх Хэмжил зүй” сэдвийн хүрээнд цахим семинарыг 5 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан.<br>2. Хэмжил зүйн үйл ажиллагааг сурталчлан танилцуулах ажлын хүрээнд олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгслээр болон олон улсын мэдээллийн сайтуудад 10 мэдээлэл бэлтгэн нийтлүүлсэн.<br>3. 20 Аймгийн СХЗХ-үүд хэмжил зүйн үйл ажиллагааг сурталчлах хүрээнд 10 хэмжих хэрэгсэл тус бүрт контент бэлтгэн сурталчилсан.<br>4. Дижитал шилжилт, дижитал хэмжил зүйн талаар хэмжил зүйн олон улсын байгууллагын материал судалж, танилцуулга бэлтгэж, ХЗБГ ба ХХШБГ-ын ажилтнуудад зориулсан дотоод 3 сургалт зохион байгуулсан.<br>5. Стандарт, хэмжил зүй сэтгүүлд “Дижитал чанарын дэд бүтэц”, “дижитал хэмжил зүй”, “дижитал шалгалт тохируулгын гэрчилгээ” сэдвийн хүрээнд болон хэмжил зүйн чиглэлээр хэвлэлийн эх, материал бэлтгэж, сэтгүүлийн 4 дугаарыг хэвлүүлсэн. | 100 |
| 5.14 | Чанарын дэд бүтцийн бүрэлдэхүүн, оролцогч ба сонирхогч талуудад чиглэсэн Дэлхийн чанарын өдрийг тэмдэглэх, Үндэсний чанарын шагнал олгох арга хэмжээг зохион байгуулах | Улсын төсөв | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 1 | 1 | “Дэлхийн чанарын чуулган”, “Үндэсний чанарын шагнал” олгох арга хэмжээг МҮХАҮТ-тай хамтран зохион байгуулах ажлын хэсэг болон шалгаруулалтын ажлын хэсэг томилогдон зохион байгуулалтын ажил хийгдэж, бэлэн болсон. Шалгаруулалтыг хийж гардуулах ажил Шадар сайдаас шалтгаалж хүлээгдэж байгаа. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.15 | Цахим хурлын танхим бий болгох | Улсын төсөв | Бий болсон цахим хурлын танхим | - | 1 | СХЗГ-аас үзүүлж буй бүх төрлийн сургалт, мэдээллийг зайнаас хүргэх зорилтын хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын албан хэрэгцээнд цахим хурлын заалны тоног төхөөрөмж нийлүүлэгдэж ашиглалтад орсон. | 100 |
| 5.16 | Байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, төрийн жинхэнэ албан тушаалд томилох, сонгон шалгаруулах, шагнах, гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг зохион байгуулах | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлд 6 удирдах албан тушаал, 30 гүйцэтгэх албан тушаалын сул орон тоон дээр тусгай шалгалтын захиалгыг хүргүүлж тусгай шалгалтад тэнцсэн 32 албан хаагчийг төрийн захиргааны албан тушаалд томилсон.<br>ТАЗ-өөс зохион байгуулсан албан тушаалын тусгай шалгалтад тэнцэж, анх удаа төрийн захиргааны албан тушаалд томилогдсон 19 албан хаагчийн Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ын дагуу 2022 онд 2 удаа зохион байгуулсан.<br>СХЗГ-ын ХХШБГ, БТБГ, ХЗБГ, СХГ-ын сул 4 ажлын байран дээр ажлын байрны захиалгыг ТАЗ рүү Газрын 2022 оны 01/855, 01/929, 01/973 тоот албан бичгээр явуулсан.<br>- "Дэлхийн хэмжил зүйн өдөр"-ийг тохиолдуулан нийт 28 албан хаагчийг СХЗГ-ын Жуух бичгээр шагнасан.<br>Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн баярыг тохиолдуулан төрийн дээд одон медалиар шагнуулах нийт 42 албан хаагчийн материалыг ШСАА-аар дамжуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн салбарын тэргүүнээр 31 албан хаагч, жуухаар 28 албан хаагчийг тус тус шагнаж урамшуулсан.<br>Ардын хувьсгалын 100 жилийн ойн медалиар шагнуулах 297 албан хаагч, ахмад ажилтнуудын мэдээллийг ЗГХЭГ болон ШСАА-д хүргүүлснээс 203 медаль ирсэн бөгөөд салбарын албан хаагчид болон ахмадуудад гардуулсан өгсөн. | 100 |
| 5.17 | ISO 9001:2016 стандартын шаардлагад үргэлжлүүлэн нийцэж байгаа эсэхэд дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ хийх | Улсын төсөв | Зохион байгуулалтын үндсэн нэгж | 4 | 8 | СХЗГ-ын даргын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/92 тушаалаар байгуулагдсан орон тооны бус чанарын хороо нь 2022 онд агентлагийн даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан 8 арга хэмжээг хэрэгжүүлснээс 2 ажил 100%, 1 ажил 90%, 1 ажил | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 80%-ын биелэлттэй. 4 ажлын биелэлт хангалтгүй байна. Манай газар дээр чанарын менежер гэсэн орон тоо байхгүй байгаа. Харин НМХГ, Мэргэжлийн хяналт дээр чанарын менежер гэсэн орон тоо байгаа тул орон тооны байхаар ирэх онд дотоод зохион байгуулалтыг хийнэ. | |
| 5.18 | Стандарт, хэмжил зүйн салбарын албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх | Улсын төсөв | Шинэчилсэн компьютер, тоног төхөөрөмжийн тоо | - | 80 | СХЗГ-ын 2022 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд СХЗГ-ын албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэх арга хэмжээ тусган хэрэгжүүлж, албан хаагчдад 80 ш компьютер, 15 ш нөтбүүк, 12 ш принтер, ухаалаг самбар 2 ш-ийг газар нэгжүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн хуваарилсан. Хуучин ашиглаж байсан компьютероос ашиглах боломжтойг нь форматлан зохион байгуулалтын үндсэн нэгж болон 20 аймгийн СХЗХ-д хуваарилсан. | 100 |
| **Дөрөвдүгээр хэсэг. БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТ** | | | | | | | |
| 6.1 | Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтын 2022 оны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах | Улсын төсөв | Төлөвлөгөөний хэрэгжилт, % | 100 | 100 | Албан хаагчдыг Төрийн албаны хуулийн дагуу төрийн албаны мэргэшүүлэх богино болон дунд хугацааны багц сургалтад нийт 31 албан хаагчийг хамруулсан. Үүнд:<br>- Бодлого, стратегийн богино хугацааны сургалтад 4 албан хаагч<br>- Эрхэлсэн түшмэлийн албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч<br>- Ахлах түшмэлийн албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч<br>- Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 6 албан хаагч<br>- Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3 албан хаагч<br>- Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 8 албан хаагч | 100% |
| 6.2 | Стандарт, хэмжил зүйн салбарын ажилтан, албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх боловсруулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах | Улсын төсөв | Хөтөлбөрийн тоо, хэрэгжилтийн хувь. | 2/70 | 2/100 | 1. "Стандарт, хэмжил зүйн салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг СХЗГ-ын даргын 2022 оны А/203 тушаалаар батлуулсан.<br>2. Шинэчлэн батлагдсан "Стандарт, хэмжил зүйн салбарын албан хаагчдын сургалт хөтөлбөр, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг Абле | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | системийн олон нийт цэс хэсэгт тавьж албан хаагчдад болон аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн албан хаагчдад мэдээлсэн.<br><br>**Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд:**<br>- Хаан, Голомт банканд цалингийн зээлийн хүүг бууруулах талаар санал хүргүүлж шийдвэрлэсэн.<br>- Цалингийн зээлтэй албан хаагчдын судалгаар салбарын хэмжээнд авч нэгтгэсэн. /400 гаруй/<br>Хаан банктай хамтран ажиллах гэрээ байгуулан бусад банкнаас хэрэглээний болон цалингийн зээлтэй албан хаагчдын судалгаар авч нэгтгэсэн. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд өндөр хүүтэй, хугацаа багатай зээл авсан салбарын албан хаагчид зээлээ Хаан банканд шилжүүлэн сарын 1,1%-ийн хүүтэй, уян хатан нөхцөл санал болгосон. | |
| | | | | | | | **92.5** |

*ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:*
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД ......................... / С.АМАРСАЙХАН/
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

...............................
*(огноо)*

*ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН:*
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ......................... /Б.УУГАНБАЯР/
*(Албан тушаал)* *(гарын үсэг)*

ХТҮ3154 9020030641 9096035

...............................
*(огноо)*